



I-X/2022

Тархаасан: 2022 оны 11 дүгээр сарын 21



Нийгмийн даатгалын орлого өмнөх оны мөн үеэс 79.8 хувиар, нийгмийн даатгалын зарлага 24.6 хувиар тус тус өсжээ.

2022 оны эхний 10 дугаар сарын байдлаар нийгмийн даатгалын 5 төрлийн санд нийт 344.9 тэрбум төгрөг төвлөрүүлсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 153.1 (79.8%) тэрбум төгрөгөөр өссөн байна.


ХҮСНЭГТ 1. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, жил бүрийн эхний 10 дугаар сарын байдлаар

Үзүүлэлт	2021 I-X	2022 I-X	<u>2022 I-X</u> 2021 I-X
	сая төгрөг		хувь
Нийт орлого	191 852.9	344 912.4	179.8
Тэтгэврийн даатгалын сангийн	169 424.9	251 178.1	148.3
Тэтгэмжийн даатгалын сангийн	10 735.8	21 573.6	2.0 ¹
Эрүүл мэндийн даатгалын сангийн	0	46 633.9	-
ҮОМШӨ ² -ний даатгалын сангийн	9 596.7	18 436.5	1.9 ¹
Ажилгүйдлийн даатгалын сангийн	2 095.5	7 090.3	3.4 ¹
Нийт зарлага	169 170.7	210 948.1	124.7
Тэтгэврийн даатгалын сангийн	145 154.2	185 672.1	127.9
Тэтгэмжийн даатгалын сангийн	16 749.9	16 164.4	96.5
ҮОМШӨ ² -ний даатгалын сангийн	1 148.7	1 362.0	118.6
Ажилгүйдлийн даатгалын сангийн	6 117.9	7 749.6	126.7

¹-дахин

²-Үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин

ЗУРАГ 1. ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, дүнд эзлэх хувиар, 2022 оны эхний 10 дугаар сарын байдлаар



Даатгалын санд хуримтлуулсан нийт шимтгэлийн орлогын 72.8 хувь нь тэтгэврийн даатгалын санд, 5.3 хувь нь үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний (ҮОМШӨ) даатгалын санд, 6.3 хувь нь тэтгэмжийн даатгалын санд, 2.1 хувь нь ажилгүйдлийн даатгалын санд, эрүүл мэндийн даатгалын санд 13.5 хувь нь тус тус төвлөрчээ.

ЗУРАГ 2. ДААТГАЛЫН САНГИЙН ЗАРЛАГА, дүнд эзлэх хувиар, 2022 оны эхний 10 дугаар сарын байдлаар



Нийгмийн даатгалын сангаас 2022 оны 10 дугаар сарын байдлаар даатгуулагч иргэдэд 210.9 тэрбум төгрөгийг тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, тусламж, үйлчилгээний зардалд зарцуулжээ. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 41.8 (24.7%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Нийт зардлын 88.0 хувийг тэтгэврийн, 0.6 хувийг ҮОМШӨ-ний, 7.7 хувийг тэтгэмжийн, 3.7 хувийг ажилгүйдлийн даатгалын сангаас олгосон зардал эзэлж байна.

ХҮСНЭГТ 2. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГУУДЫН ЗАРЛАГА, жил бүрийн эхний 10 дугаар сарын байдлаар


Үзүүлэлт	Тэтгэвэр, тэтгэмж авагчид			Олгосон тэтгэвэр, тэтгэмж		
	2021 I-X	2022 I-X	$\frac{2022 \text{ I-X}}{2021 \text{ I-X}}$	2021 I-X	2022 I-X	$\frac{2022 \text{ I-X}}{2021 \text{ I-X}}$
	тоо		хувь	сая төгрөг		хувь
НД-ын сангийн нийт зарлага	60 739	59 302	97.6	169 170.7	210 948.1	124.7
Тэтгэврийн даатгалын сан	29 995	31 447	104.8	145 154.2	185 672.1	127.9
Өндөр насны	23 206	24 449	105.3	117 085.4	148 291.9	126.7
Тахир дутуугийн	4 018	4 128	102.7	12 928.4	17 346.8	134.2
Тэжээгчээ алдсаны	1 073	1 111	103.5	3 387.5	4 834.8	142.7
Цэргийн тэтгэвэр	1 698	1 759	103.5	11 752.9	15 198.6	129.3
Тэтгэмжийн даатгалын сан	27 895	24 757	88.7	16 749.9	16 164.4	96.5
Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж	20 996	19 167	91.2	3 369.0	3 534.9	104.9
Жирэмсэн, амаржсаны тэтгэмж	6 809	5 518	81.0	13 291.9	12 557.5	94.5
Оршуулгын тэтгэмж	90	72	80.0	89.0	72.0	80.9
ҮОМШӨ*-ний даатгалын сан	274	312	113.8	1 148.7	1 362.0	118.2
Тахир дутуугийн тэтгэмж	175	167	95.4	932.0	1 073.1	115.1
Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	25	22	88.0	162.1	180.8	111.5
Тэтгэмж, төлбөр	69	101	143.6	53.3	103.6	194.4
ҮОМШӨ*-ний сувилал	5	22	44.0 ¹	1.3	4.5	3.5 ¹
Ажилгүйдлийн даатгалын сан	2 575	2 786	108.1	6 117.9	7 749.6	126.7
Ажилгүйдлийн тэтгэмж	2 575	2 786	108.1	6 117.9	7 749.6	126.7

¹-дахин

²-Үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин

Оны эхний 10 дугаар сарын байдлаар нийгмийн даатгалын сангаас 59302 хүнд 210.9 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж олгогдсоны 31447 хүнд 185.7 тэрбум төгрөгийг тэтгэврийн даатгалын сангаас, 24757 хүнд 16.1 тэрбум төгрөгийг тэтгэмжийн даатгалын сангаас, 2786 хүнд 7.7 тэрбум төгрөгийг ажилгүйдлийн даатгалын сангаас, 312 хүнд 1.4 тэрбум төгрөгийг үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангаас тус тус зарцуулсан байна.

ЗУРАГ 3. ДААТГАЛЫН САНГИЙН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ АВАГЧДЫН ТОО, 2022 оны эхний 10 дугаар сарын байдлаар



2022 оны эхний 10 дугаар сарын байдлаар тэтгэврийн даатгалын сангаас 31447 хүнд 185.6 тэрбум төгрөгийн тэтгэвэр олгогдсоны 79.9 хувийг өндөр настны, 9.3 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, 2.6 хувийг тэжээгчээ алдсаны, 8.2 хувийг цэргийн тэтгэвэр тус тус эзэлж байна. Тэтгэвэр авагчийн 79.9 хувийг өндөр настны тэтгэвэр эзэлж байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 1243 (5.4%) хүнээр, 31.2 (26.7%) тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

Өнгөрсөн оны мөн үеэс нийт тэтгэмж авагчийн тоо 3138 (11.1%) хүнээр буурч, олгосон тэтгэмжийн хэмжээ 585.6 (3.5%) сая төгрөгөөр буурсан байна.

НИЙГМИЙН ХАЛАМЖ

Нийгмийн халамж нь орлого багатай, хүүхэд, өндөр настан зэрэг зорилтот бүлэгт чиглэсэн арга хэрэгсэл юм. Нийгмийн халамжийн сангаар 2022 оны эхний 10 дугаар сарын байдлаар нийт 1164.9 мянган хүнд 115432.9 сая төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламж олгогдож, өнгөрсөн оны мөн үеэс 75.8 (6.1%) мянган хүнээр, 5198.9 (4.3%) сая төгрөгөөр тус тус буурчээ.

Олгосон тэтгэвэр, тэтгэмжийн 91171.1 (79.0%) сая төгрөгийг хүүхдийн мөнгөн тэтгэмж, 7122.8 (6.2%) сая төгрөгийг тэтгэвэрт, 5717.0 (4.9%) сая төгрөгийг эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эцэг, эхийн тэтгэмж, 3200.2 (2.8%) сая төгрөгийг асаргааны тэтгэмж, 2687.6 (2.3%) сая төгрөгийг амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж, 1948.3 (1.7%) сая төгрөгийг насны хишигт, 1354.9 (1.2%) сая төгрөгийг алдарт эхийн одонгийн мөнгөн тэтгэмж, 1593.3 (1.4%) сая төгрөгийг ахмад настны тэтгэмж, хөнгөлөлт, үлдсэн 637.7 (0.5%) сая төгрөгийг алдар цолтой ахмад настанд олгох хөнгөлөлт, тусламж, онцгой тохиолдолд олгох мөнгөн тэтгэмж, хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлт, тусламж тус тус эзэлж байна.

ХҮСНЭГТ 3. НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН ЗАРЛАГА, төрлөөр, жил бүрийн эхний 10 дугаар сарын байдлаар

Үзүүлэлт	2021 I-X		2022 I-X		<u>2022 I-X</u> 2021 I-X
	Хүн	Гүйцэтгэл	Хүн	Гүйцэтгэл	
	тоо	сая төгрөг	тоо	сая төгрөг	хувь
НИЙТ ОЛГОГДСОН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ	1 240 666	120 631.8	1 164 914	115 432.9	95.7
Тэтгэвэр	25 061	7 004.4	27 882	7 122.8	101.7
Асаргааны тэтгэмж	34 476	3 058.5	36 116	3 200.2	104.6
Амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж	14 857	2 367.0	17 750	2 687.6	113.5
Эх, олон хүүхэдтэй ерх толгойлсон эх, эцгийн тэтгэмж	122 105	6 109.3	113 908	5 717.0	93.6
Алдарт эхийн одонгийн тусламж	10 799	1 304.8	11 342	1 354.9	103.8
Алдар цолтой ахмад настанд олгох хөнгөлөлт, тусламж	311	54.1	331	76.3	141.0
Хүүхдийн мөнгө	970 887	97 088.7	911 711	91 171.1	93.9
Насны хишиг	22 796	1 857.3	24 028	1 948.3	104.9
Онцгой тохиолдолд олгох мөнгөн тэтгэмж	15	18.0	29	34.8	193.3
Ахмад настны тэтгэмж, хөнгөлөлт	8 322	930.7	16 285	1 593.3	171.1
Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлт, тусламж	4 682	443.1	5 011	448.9	101.3
Бусад	26 355	395.9	521	77.7	19.6

Оны эхний 10 дугаар сарын байдлаар 16285 ахмадад 1593.3 сая төгрөгийн ахмад настны тэтгэмж, хөнгөлөлт зарцуулагдаж, өмнөх оны мөн үетэй харьцуулбал 7963 (95.7%) хүнээр, 662.6 (71.2%) сая төгрөгөөр өссөн байна.

ХҮСНЭГТ 4. АХМАД НАСТНЫ ТЭТГЭМЖ, ХӨНГӨЛӨЛТ, төрлөөр, жил бүрийн эхний 10 дугаар сарын байдлаар

Үзүүлэлт	2021 I-X		2022 I-X		<u>2022 I-X</u> 2021 I-X
	Хүн	Гүйцэтгэл	Хүн	Гүйцэтгэл	
	тоо	мянган төгрөг	тоо	мянган төгрөг	хувь
Бүгд	8 322	930 701.0	16 285	1 593 290.6	171.2
Оршуулгын тэтгэмж	19	19 000.0	18	18 000.0	94.7
Амралт, сувилал	1 423	240 505.0	2 824	464 320.0	193.1
Рашаан, сувилал	949	184 342.5	3 591	557 148.0	3.0 ¹
Протез	1 699	272 543.5	2 320	289 826.6	106.3
Ортопед	593	115 735.0	360	155 155.0	134.1
Тусгай хэрэгсэл	397	57 055.0	259	31 001.0	54.3
Ахмадын хүндэтгэл	3 172	31 720.0	6 846	68 460.0	2.2 ¹
Түлш болон орон сууцны үнийн хөнгөлөлт	70	9 800.0	67	9 380.0	95.7

¹-дахин

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлт, тусламжийг өмнөх оны мөн үетэй харьцуулан харвал хүний тоо 329 (7.0%)-өөр, олгосон тэтгэмж 5784.4 (1.3%) сая төгрөгөөр тус тус өсжээ.

ХҮСНЭГТ 5. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭНИЙ ХӨНГӨЛӨЛТ, ТУСЛАМЖ, ТӨРЛӨӨР, ЖИЛ БҮРИЙН ЭХНИЙ 10 ДУГААР САРЫН БАЙДЛААР

Үзүүлэлт	2021 I-X		2022 I-X		2022 I-X
	Хүн	Гүйцэтгэл	Хүн	Гүйцэтгэл	2021 I-X
	тоо	мянган төгрөг	тоо	мянган төгрөг	хувь
Бүгд	4 682	443 075.7	5 011	448 860.1	101.3
Харилцаа холбооны зардлын хөнгөлөлт	2 883	57 170.5	2 990	59 469.9	104.0
Оршуулгын тэтгэмж	27	27 000.0	34	34 000.0	125.9
Цэцэрлэг сургуулийн унааны зардал	294	58 800.0	379	75 800.0	128.9
Рашаан сувилал	168	45 144.2	254	59 377.2	131.5
Протез	192	28 428.0	184	27 381.0	96.3
Ортопед	110	35 865.0	119	40 305.0	112.4
Тусгай хэрэгсэл	239	50 160.0	128	23 307.0	46.5
Түлш болон орон сууцны үнийн хөнгөлөлт	765	107 100.0	923	129 220.0	120.7
Бусад	4	33 408.0	-	-	-

¹дахин

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөнгөлөлт, тусламж авсан нийт хүний дийлэнх буюу 59.7 хувийг харилцааны холбооны зардлын хөнгөлөлт авсан хүн эзэлж байгаа боловч олгосон тэтгэмж нь 13.2 хувийг эзэлж байна.

Ойлголт, тодорхойлолт:

Нийгмийн даатгал: Иргэн, төр, аж ахуйн нэгж, байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын санг бүрдүүлэн, даатгуулагч иргэн өндөр наслах, хөгжлийн бэрхшээлтэй буюу хөдөлмөрийн чадваргүй болох, өвчлөх, ажилгүй болох үед өөрт нь, тэрчлэн нас барахад түүний асрамжид байсан хүмүүст хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгох зориулалттай нийгэм, эдийн засгийн арга хэмжээ юм.

Нийгмийн даатгалын сан: Ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үйлчилгээнд зарцуулах, нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдүүлсэн мөнгөн хөрөнгийг хэлнэ.

Даатгуулагч: Хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг хэлнэ.

Тэтгэвэр: Даатгуулагчийг өндөр наслахад насан туршид нь, хөдөлмөрийн чадвараа алдсан бол хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, эсхүл өндөр насны тэтгэвэр авах насанд хүртэл, нас барахад нь түүний асрамжид байсан гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүнд нийгмийн даатгалын сангаас сар бүр олгох мөнгөн олговор юм.

Тэтгэмж: Хөдөлмөрийн чадвараа түр хугацаагаар алдах, жирэмсний, амаржсаны чөлөө эдлэх, ажилгүй болох тохиолдолд даатгуулагч өөрт нь, даатгуулагч нас барах тохиолдолд гэр бүлд нь хууль заасан болзол, нөхцөлийн дагуу нийгмийн даатгалын сангаас тодорхой хугацаанд буюу нэг удаа олгох мөнгөн олговор байна.

Нийгмийн халамж: Эрүүл мэндийн доройтолтой, гэр бүлийн халамж, асрамж дутагдалтай, бие даан, эсхүл бусдын тусламжгүйгээр хэвийн амьдрах боломжгүй, өвөрмөц хэрэгцээ бүхий иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнд наад захын хэрэгцээг нь хангах зорилгоор улсаас тэтгэвэр, тэтгэмж олгох, тусгайлсан үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг нийгмийн халамж гэнэ.

Байнгын асаргаа шаардлагатай иргэн: Бусдын туслалцаагүйгээр өдөр тутмын үйлдлээ бие даан гүйцэтгэх чадваргүй, эсхүл оюуны хөгжлийн бэрхшээлтэй, сэтгэцийн хүнд хэлбэрийн эмгэгтэй хүнийг хэлнэ.

Бүтэн өнчин хүүхэд: Эцэг, эх нь тогтоогдоогүй, эсхүл эцэг, эх нь хоёул нас барсан, сураггүй алга болсон, эрх зүйн чадамжгүй, эцэг, эх байх эрхээ шүүхийн шийдвэрээр хязгаарлуулсан, хасуулсан бол тухайн шийдвэр хүчин төгөлдөр байх хугацаанд, түүнчлэн эцэг тодорхойгүйн улмаас эхтэйгээ амьдарч байгаад эх нь нас барсан, гэр бүл салсны улмаас асрамждаа авсан эх/эцэг/ нь нас барсан 18 хүртэлх насны хүүхдийг хэлнэ.

Өрх толгойлсон эх /эцэг/: Нөхөр, эхнэрийн аль нэг нь нас барсан, эсхүл сураггүй алга болсон нь шүүхээр тогтоогдсон, гэрлэлтээ цуцлуулсан, эцэг, эх байх эрхээ шүүхийн шийдвэрээр хязгаарлуулсан, хасуулсан бол тухайн шийдвэр хүчин төгөлдөр байх хугацаанд, гэрлэж байгаагүй боловч төрүүлсэн болон үрчлэн авсан хүүхэдтэй ганц бие эх /эцэг/-ийг хэлнэ.

Төрөлжсөн асрамжийн үйлчилгээ: Асран хамгаалах, харгалзан дэмжих төрөл, садангүй бөгөөд бие даан амьдрах чадваргүй, ганц бие, байнгын эмчилгээ, асаргаа шаардагдах ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэн, түүнчлэн хүнд нөхцөлд байгаа хүүхдийг байрлуулан хоол, хувцас, эмнэлэг, соёл, ахуй, сэтгэл зүй, асаргаа сувилахуйн үйлчилгээ үзүүлэх, тэдний амьдралын хэвийн нөхцөлийг бүрдүүлэх, хууль ёсны эрх ашгийг нь хууль тогтоомжид заасны дагуу хамгаалах үйл ажиллагаа хэлнэ.

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ: Иргэн, аж ахуйн нэгж, төр болон төрийн бус байгууллагын оролцоотойгоор өрх, иргэнд дэмжлэг туслалцаа, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг хэлнэ.

Эх үүсвэр:

Дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн сарын мэдээ
Дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс

Дараагийн танилцуулга тархаах хугацаа:

2022 оны 12 дугаар сарын 20

Мэдээлэл авах холбоос:

<http://www.ubstat.mn/>

Статистикийн хэлтсийн дарга
Г.Чинжаргал
Утас: (976)-70122666

Статистикийн хэлтсийн мэргэжилтэн
П.Чимгээ
Утас: (976-11)-301637